



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2020-02-18 № 4-1/820
танай _____ -ны № _____ -т

**ХАРЬЯА ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ**

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/100 дугаар тушаалыг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт эрүүл мэндийн ажилтнуудын нэгэн адил ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох тухай шийдвэрийг баталсан тул баримтлан ажиллана уу

ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА *Нарантуяа* Д.НАРАНТУЯА



145201117



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар A/100

Улаанбаатар хот

Үр дүнгийн урамшуулал олгох тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн 14.2.3, 14.2.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарын ажлын үр дүн, гүйцэтгэлийг тухайн байгууллагын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн шийдвэрийг үндэслэн эрүүл мэндийн ажилтнуудын нэгэн адил улирал тутам үндсэн цалингийн 30-60 хувиар тооцож мөнгөн урамшуулал олгосугай.

2. Удирдлагын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн мөнгөн урамшууллыг улирал тутам олгохыг байгууллагын ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

141200362